

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**0,4кВ-ын шугам, тоноглолын урсгал
засварын материал нийлүүлэгчийг сонгон
шалгаруулах тендерийн баримт бичиг**

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/47

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

0,4кВ-ын шугам, тоноглолын урсгал засварын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 10-р сарын 14-н өдрийн 10 цагаас өмнө ирүүлнэ.

Үнийн саналтын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 10-р сарын 14-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99105839

Факс: 70210167

ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p align="center">Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ. 2. Маягтын дагуу үнийн санал ирүүлнэ. 3. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт ирүүлнэ. 4. Тендерийн баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим хаягаар ирүүлнэ. 5. Нийлүүлэгч ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 6. Нийлүүлэх хугацаа: 14 хоногоос ихгүй 7. Одоо хэрэгжүүлж буй бараа материал нийлүүлж байгаа гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлнэ.
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү бараа материал нийлүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2019 оны 10 дугаар сарын 14 өдөр Цаг: 10 цаг 00 минут.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Багануур дүүрэг 3-р хороо Үйлдвэр хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК өөрийн байр Давхар болон өрөөний дугаар: “БЗӨБЦТС” ТӨХК –н өөрийн байр 2-р давхар 202 тоот Огноо: 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ. 2. Сүүлийн хоёр жилийн аль нэг жилийн борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 3. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-ын тодорхойлолтуудыг ирүүлнэ. 4. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх, мөн татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ.
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна. ХА.№19/47, 0,4кВ-ын шугам, тоноглолын урсгал засварын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер. Багцтай эсэх: Үгүй</p>

ГУРАВ. БАРАА МАТЕРИАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

№	Материалын нэр	Нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Автомат	ш	159	1 фазын 32 А-ын автомат
2		ш	2	3 фазын 250 А-ын автомат
3		ш	48	1 фазын 80 А-ын автомат
4		ш	5	3 фазын 160 А-ын автомат
5		ш	150	1 фазын 25 А-ын автомат
6		ш	19	3 фазын 50 А-ын зам дээр суурилуулдаг
7		ш	29	3 фазын 80 А-ын зам дээр суурилуулдаг
8		ш	10	3 фазын 250 А-ын зам дээр суурилуулдаг
9		ш	110	1 фазын 63 А-ын автомат
10		ш	9	3 фазын 100 А-ын автомат
11		ш	50	32 А-ын 2 фазын автомат
12	Хөндрийрүүлэгч	ш	15	Штырт изолятор / Р-15Т дүйцэхүйц /
13	Кабель	м	103	АВБбШв маркын кабельтай дүйцэхүйц, 3*50+1*25 мм2 хөндлөн огтлол талбайтай
14	Лент /хөндийрүүлэгч/	ш	596	1*10 см шар, ногоон, улаан өнгийн
15	1 Фазын рубильник	ш	5	100 А-ын 1 фазын рубильник
16	"О"-н клем	ш	150	9 боолтны нүхтэй, тусгаарлагчтай, 0.4 кВ-ын щитний хайрцагт байрлуулах зориулалт бүхий
17	Автоматны зам	м	70	1 м урттайгаар тайрсан, автомат суурилуулах боломжтой 0.5 мм дээш зузаантай төмөр
18	Багцлагч	боодол	2	5 мм-ийн өргөнтэй багцлагч
19	Батарей	ш	12	9 В-ын дөрвөлжин баттерей
20	Боолт, шайк, шайб	ш	36	Ø10 диаметртай, боолт, гайк, шайбын хамт
21	Боолт	ш	650	Ø14 боолт, 0.4 кВ щитэнд газардуулга хийх
22	Гайк, даравч	ш	650	Ø15 гайк, даравч, 0.4 кВ щитэнд газардуулга хийх
23	Гал хамгаалагч	ком	1	0.4 кВ-ын 630 А-ын суурийн гал хамгаалагч
24		ш	6	0.4 кВ-ын 100 А-ын нарийн гал хамгаалагч
25		ш	3	0.4 кВ-ын 100 А-ын бүдүүн гал хамгаалагч
26		ш	12	6-10 кВ-ын 10 А-ын, 40 см урттай гал хамгаалагч
27		ш	11	6-10 кВ-ын 20 А-ын, 40 см урттай гал хамгаалагч
28		ш	12	6-10 кВ-ын 30 А-ын, 40 см урттай гал хамгаалагч
29		ш	16	ПК-100 А дүйцэхүйц
30		ш	6	RN-6 дүйцэхүйц 100 А-ын 38*6.5 см хэмжээтэй гал хамгаалагч
31		ш	3	RN-6 дүйцэхүйц 10 А-ын 3*5.5 см хэмжээтэй гал хамгаалагч
32		ш	6	RN-6 дүйцэхүйц 20 А-ын 41*5 см хэмжээтэй гал хамгаалагч
33	Гүйдлийн трансформатор	ш	3	ТТИ-40 маягийн 150/5 коэффициенттэй гүйдлийн трансформатор, гэрчилгээтэй
34		ш	6	ТТИ-40 маягийн 250/5 коэффициенттэй гүйдлийн трансформатор, гэрчилгээтэй

35		ш	9	ТТИ-40 маягийн 400/5 коэффициенттэй гүйдлийн трансформатор, гэрчилгээтэй
36	Дохиоллын гэрэл	ш	10	Хувьсах, тогтмол ажилладаг, улаан өнгийнх байх
37	Дохиоллын хонх	ш	2	Хувьсах 220 В-иор ажилладаг, Дэд станцад дохиоллын зориулалтаар ашиглах хонх
38	Дундын муфть	ш	7	0.4 кВ-ын 70-120 мм ² кабельд ашиглах, БНХАУ үйлдвэрлэсэн дундын муфьт
39		ш	6	6 кВ-ын 70-120 мм ² кабельд ашиглах, ОХУ үйлдвэрлэсэн дундын муфьт
40	Төгсгөлийн муфть	ш	2	0.4 кВ-ын 50-95 мм ² кабельд ашиглах, ОХУ үйлдвэрлэсэн төгсгөлийн муфьт
41		ш	6	6 кВ-ын 70-120 мм ² кабельд ашиглах, ОХУ үйлдвэрлэсэн төгсгөлийн муфьт
42	Заагч реле	ш	3	Хувьсах 220В ажилладаг, РУ-21 марктай дүйцэхүйц
43	Изолятор	ш	61	ШП-6 маягийн хөндийрүүлэгч
44		ш	50	ШП-10 маягийн хөндийрүүлэгч
45	Кабель	м	58	АВВГ 2*16 кабель
46		м	60	АВВГ 3*16 кабель
47		м	70	АБЛУ-3*70 кабель
48		м	30	АВВГн 3*50+1*35 кабель
49		м	21	АВБбШв маркын кабельтай дүйцэхүйц, 3*70+1*35 мм ² хөндлөн огтлолын талбайтай
50		м	50	2.5*6 хэмжээтэй хяналтын кабель байна.
51		м	30	АВБбШв маркын кабельтай дүйцэхүйц, 3*50+1*35 мм ² хөндлөн огтлолын талбайтай
52		м	30	АВВГн 3*70+1*35 кабель
53	Кемприк	м	10	Цагаан өнгийн, хөндийрүүлгийн зориулалтаар ашиглах лент
54	Клем	ш	138	3.5 Автоматны зам дээр суух гүйдлийн клем
55	Круг төмөр	м	290	Ø22 мм ² хэмжээтэй дугуй төмөр
56		ш	2750	Нэг удаагийн зориулалт бүхий, цифр дугаартай лац
57	Монтажны утас	м	933	4 мм ² голчтой, зэс дамжуулагч бүхий монтажны утас
58		м	42	8 мм ² голчтой, зэс дамжуулагч бүхий монтажны утас
59		м	200	2*2.5 мм ² голчтой, зэс дамжуулагч бүхий монтажны утас
60		м	42	1*16 мм ² голчтой, зэс дамжуулагч бүхий монтажны утас
61		м	942	1*2.5 мм ² голчтой, зэс дамжуулагч бүхий монтажны утас
62	Нүхтэй боолт	ш	40	Тоолуурын таг боох зориулалттай
63	Салбарлагч	ш	10	35-50 мм ² дамжуулагч утасанд ашиглах 0.4 кВ СИП дамжуулагчид ашиглах салбарлагч
64	Салгуур 10кВ	ком	2	10 кВ-ын, 400 А-ын, 1 газардуулгын хутгатай, РЛНДЗ-10/400 маягтай дүйцэхүйц
65	Татагч	ш	22	0.4 кВ-ын 4 утасны татагч 50 мм ² багагүй дамжуулагч утасных
66	Татуурганы тросс	ком	10	0.4 кВ-ын 4 утасны татагчинд хэрэглэх 50 мм ² багагүй дамжуулагч утасных татуургын тросс

67	Тоолуурын хайрцаг	ш	5	40*60 см хэмжээтэй тоолуурын хайрцаг, 0.5 мм багагүй зузаантай байх
68	Төгсгөвч	ш	724	Ø16 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
69		ш	40	Ø35 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
70		ш	273	Ø50 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
71		ш	221	Ø70 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
72		ш	299	Ø25 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
73		ш	65	Ø95 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
74		ш	100	Ø195 хэмжээтэй, хөнгөнцагаан төгсгөвч
75	Трансформаторын тагны резин	ш	9	ТМ-6/250 маркын трансформаторынх-2ш, ТМ-6/400 маркын трансформаторынх-2 ш, ТМ-6/100 маркын трансформаторт-5 ш
76	Туузан төмөр	тн	0.3	4*40 мм хэмжээтэй туузан төмөр
77	Хуруувч резин	ш	2	Ø10 диаметртэй хуруувч резин
78		ш	3	Ø12 диаметртэй хуруувч резин
79		ш	6	Ø14 диаметртэй хуруувч резин
80	Хэмжүүр (SETAK)	ком	1	Олон үйлдэлт SETAK хэмжүүртэй дүйцэхүйц
81	Хяналтын гэрэл	ш	5	Хувьсах 220 В-иор ажилладаг, Дэд станцад хяналтын гэрлийн зориулалтаар ашиглах ногоон гэрэл
82	Цүү	ш	75	0.4 кВ-ын шитний хайрцагт цоож зүүхэд хэрэглэх
83	Цэвэрлэх бодис	ш	8	Зэв арилгагч
84	Шит	ком	5	0.4 кВ-ын иж бүрэн шит, 4 тоолуур суурилуулах боломжтой
85		ком	10	0.4 кВ-ын иж бүрэн шит, 6 тоолуур суурилуулах боломжтой

2. Стандарт: Монгол улсын зохих стандартад нийцсэн байна.

3. Бараа хүргэх газар: Улаанбаатар хот Багануур дүүрэг БЗӨБЦТС-ТӨХК өөрийн байр

4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

ДӨРӨВ. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дугаар сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хуанлийн хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
БАРАА МАТЕРИАЛЫН ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх ижил төстэй гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ТАВ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 /нэг/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Бараа материалыг ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтээр бараа материалыг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;3) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний дүнгийн нэг хоногийн 0,5%</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний дүнгийн 10%</p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]